

## МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар <u>50</u>5

Улаанбаатар хот

"Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам" батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.7, 56 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

- 1. "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам"-ыг хавсралтаар баталсугай.
  - 2. Энэхүү журмыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
- 3. Энэхүү журамд заасны дагуу өөрийн компанийн үйл ажиллагааны талаар нийтэд тогтмол мэдээллийг хүргэх боломж бүрдүүлсэн цахим хуудас нээж ажиллуулж Үнэт цаасны газарт 2014 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдэгдэхийг нийт үнэт цаас гаргагч компаниудын удирдлагад үүрэг болгосугай.
- 4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



O DESCRIPTION

Санхуугийн зохицуулах хорооны 2013 оны Ддугаар сарын Д.-ны өдрийн 505. дугаар йогтоолын хавсралт

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС МЭДЭЭЛЛИЙГ
НИЙТЭД ТОГТМОЛ ХҮРГЭХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Үнэт цаас гаргагч нь нийтэд хагас жил, жилийн эцсийн байдлаар болон тогтмол нээлттэй мэдээллэхээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хороо болон хөрөнгийн биржийн холбогдох журамд заасан аливаа мэдээллийг цаг тухайд нь нэгэн зэрэг, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 1.3. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 1.2-д заасан аливаа мэдээллийг нийтэд Монгол хэлээр хүргэнэ.
- 1.4. Мэдээллийг нээлттэй болгох ажиллагааг үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага гүйцэтгэх ба энэ ажиллагаанд төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ хяналт тавьж ажиллана.
- 1.5. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ойлгохоос гадна дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:
- 1.5.1. "мэдээллийг нээлттэй болгох" гэж үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэхийг;
- 1.5.2. "тухай бүр мэдээлэх" гэж үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос тогтоосон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэхийг;
- 1.5.3. "дотоод мэдээлэл эзэмшигч" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д болон "Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай" журамд заасан этгээдийг;
- 1.5.4. "давхар бүртгэл" гэж гадаад улсын хөрөнгийн биржид үндсэн бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Монгол Улсын үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэж, арилжахыг;
- 1.5.5. "хугацаат тайлан" гэж үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг.

### Хоёр. Хугацаат тайланг нийтэд мэдээлэх

- 2.1. Үнэт цаас гаргагчийн хугацаат тайланд хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан хамаарах бөгөөд эдгээр тайлангууд нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг агуулсан байна.
- 2.2. Үнэт цаас гаргагч нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэнэ.
  - 2.3. Хагас жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:
- 2.3.1. үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
- 2.3.2. тухайн үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзэлж буй байр суурь;
- 2.3.3. үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;
- 2.3.4. үнэт цаас гаргагчийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл;
- 2.3.5. үнэт цаас гаргагчийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
- 2.3.6. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;
- 2.3.7. үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл;
  - 2.3.8. үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;
  - 2.3.9. үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
  - 2.3.10. үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
- 2.9.11. үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөл аливаа шийдвэр;
  - 2.3.12. нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
  - 2.7.13. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.
- 2.4. Үнэт цаас гаргагчийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 2.5. Үнэт цаас гаргагчийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд энэ журмын 2.3-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг тусгасан байна:
- 2.5.1. үнэт цаас гаргагчийн удирдлага, холбогдох эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;

- 2.5.2. аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлт;
- 2.5.3. тухайн жилийн санхүүгийн тайлангаар үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа;
- 2.5.4. үнэт цаас гаргагчийн хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээлэл;
  - 2.5.5. үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого;
  - 2.5.6. жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлтийн мэдээлэл;
- 2.5.7. бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл;
- 2.5.8. тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
  - 2.5.9. ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан;
  - 2.5.10. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
- 2.5.11. Монголын компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлсэн талаарх тайлан, хэрэв кодексын тодорхой заалтыг мөрдөөгүй бол түүний шалтгаан, тайлбар, хэзээ мөрдөж эхлэх хугацаа;
  - 2.5.12. энэ журмаар тухай бүр нээлттэй болгохоор заасан мэдээллийг нэгтгэсэн товчоо;
  - 2.5.13. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.
- 2.6. Хэрэв үнэт цаас гаргагчийн хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нийтэд мэдээлэхээс өмнө үнэт цаас гаргагчийн ашиг, алдагдлын хэмжээ нийтэд тархаж энэ нь тухайн үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасны үнэ ханшийг 15 хувь өөрчлөгдөхөд хүргэсэн бол үнэт цаас гаргагч тухайн тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн талаар нэн даруй нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.
- 2.7. Үнэт цаас нь гадаад улсад үндсэн бүртгэлтэй, Монгол Улсад давхар бүртгэлтэй үнэт цаас гаргачийн хувьд энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэхдээ цагийн бүсийн зөрүүг харгалзан мэдээллийг нэгэн зэрэг мэдээлнэ.
- 2.8. Давхар бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан хагас жилийн болон жилийн эцсийн тайланг Монгол хэлээр гаргаж Хороо, хөрөнгийн биржид хүргүүлнэ.
- 2.9. Давхар бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь тухай бүр тогтмол хүргэх мэдээллийг англи хэлээр гаргаж, товч утга холбогдох тоон үзүүлэлтийг Монгол хэлээр гаргах үүрэгтэй.

### Гурав. Тухай бүр нээлттэй мэдээлэх мэдээлэл

- 3.1. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр нийтэд мэдээлдэг байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 3.2 Үнэт цаас гаргагчаас тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурдсан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тооцох ба эдгээрийг тухайн үйл явдал, өөрчлөлт

болсоноос хойш ажлын 2 өдөрт багтаан өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

- 3.2.1. үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
- 3.2.2. үнэт цаас гаргагч үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;
- 3.2.3.үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
- 3.2.4. үнэт цаас гаргагчийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 3.2.5. үнэт цаас гаргагч салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах тухай мэдээлэл;
- 3.2.6. үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 3.2.7. нийт ажиллагсадын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
- 3.2.8. бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах;
- 3.2.9. үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;
- 3.2.10. үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;
- 3.2.11. үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;
- 3.2.12. үнэт цаас гаргагчийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
- 3.2.13. үнэт цаас гаргагч хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
  - 3.2.14. үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх болон хязгаарлах;
  - 3.2.15. сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэл;
- 3.2.16. үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь үнэт цаас гаргагчийн хувьцааг эзэмшиж байгаа бол/;
- 3.2.17. үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 3.2.18. үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц, түүний бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт орох:
  - 3.2.19. үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн өөрчлөгдөх;

- 3.2.20. үнэт цаас гаргагчийн өрийг хувьцаагаар солих шийдвэр;
- 3.2.21. хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч үнэт цаас гаргагчийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;
  - 3.2.22. компанийг өөрчлөн байгуулах шийдвэр;
  - 3.2.23. компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр;
  - 3.2.24. үнэт цаас гаргагч өр төлбөрөө эргэн төлөх санхүүгийн чадваргүй болох;
- 3.2.25. үнэт цаас гаргагчийн охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох;
  - 3.2.26. үнэт цаас гаргагчийг татан буулгах шийдвэр;
- 3.2.27. үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, болон бусад эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой гэмт үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
  - 3.2.28. үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
- 3.2.29. үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;
  - 3.2.30. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.
- 3.3. Үнэт цаас гаргагч энэхүү журмын 3.2 дах заалтад заасан мэдээллийг нээлттэй болгохдоо Хороо, хөрөнгийн биржид тухайн асуудлаар гарсан албан ёсны шийдвэрийг ажлын 1 өдөрт багтаан хүргүүлнэ.
- 3.4. Журмын 3.2-т заасан мэдээллийг нийтэд мэдээллэх, хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавих этгээдийг гүйцэтгэх захирал томилох бөгөөд тухайн ажилтан болон гүйцэтгэх захирал компанийн тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
- 3.5. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд огцом өөрчлөлт гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авна:
- 3.5.1. энэхүү журмын 3.2-д заасан өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээлэл нь тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар судалж, холбогдох үндэслэл бүхий тайлбарыг хөрөнгийн биржид хуанлийн 3 өдөрт мэдэгдэнэ.
- 3.5.2. үнэт цаас гаргагчийн удирдлага тухайн огцом өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид сөргөөр нөлөөлнө гэж үзвэл энэ талаар олон нийтэд ажлын 1 өдөрт багтаан мэдээлнэ.
- 3.6. Хэрэв үнэт цаас гаргагчийн охин болон хараат компанийн үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар нийтэд хуанлийн 2 хоногт мэдээлэх үүрэгтэй.
- 3.7. Хороо, хөрөнгийн бирж нь үнэт цаас гаргагчаас нийтэд хүргэх мэдээлэл, хугацаат тайланд орсон тоон үзүүлэлт, санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг нэмж шаардаж хөрөнгө оруулагчдад танилцуулах эрхтэй.

3.8. Хороо болон хөрөнгийн биржид өгөгдсөн мэдээллээс бусад цуурхал, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тархсан мэдээлэл нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхөөр бол Хороо үнэт цаас гаргагчаас нэмж мэдээлэл, тайлбар шаардах эрхтэй.

### Дөрөв. Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх

- 4.1. Үнэт цаас гаргагчийн мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах дотоод журмыг үнэт цаас гаргагчийн ТУЗ баталж, үйл ажиллагаандаа мөрдөх ба уг журамд дараах зүйлийг тусгана:
  - 4.1.1. мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааны дараалал, хяналт;
- 4.1.2. мэдээллийг хөрөнгийн бирж, Хороонд мэдээллэхээр томилогдсон эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал;
- 4.1.3. мэдээллийг нийтэд хүргэх чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж, мэдээллийн чанарт баталгаа гаргах талаарх дотоод хяналтын албаны үүрэг, хариуцлага;
- 4.1.4. мэдээллийг тайлагнах, нээлттэй болгоход үнэт цаас гаргагчийн ТУЗ, түүний нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлага;
- 4.1.5. дотоод мэдээлэл эзэмшигчдийн жагсаалт, тэдгээрийн арилжаанд оролцох журам, хязгаарлалт, хүлээх үүрэг, хариуцлага;
  - 4.1.6. үнэт цаас гаргагчийн охин, хараат, зэргэлдээ компанитай холбоотой мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагаа;
  - 4.1.7. нийтэд мэдээлсэн мэдээллийн архивыг бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаа.
- 4.2. Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдийн хүртээл болохоор зохион байгуулж, мэдээллийг таван жилийн хугацаанд нийтэд ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- 4.3. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компаниас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан үр дагаврыг хариуцана.

# Тав. Мэдээллийг нээлттэй болгоход тавигдах хязгаарлалт, хориглох зүйлс

- 5.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг энэхүү журамд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 5.2. Үнэт цаас гаргагчаас Хороо, хөрөнгийн биржид өгсөн мэдээллийг холбогдох ажилтнууд энэ журам болон бусад холбогдох хууль тогмоомжийн дагуу олон нийтэд нээлттэй болгох хүртэл нууцад тооцон хадгалах ёстой. Энэ журам болон бусад холбогдох хууль тогтоомжоор нийтэд хүргэхээр заасан мэдээлэл, шүүхийн шийдвэр нь нууцад хамаарагдахгүй болно.
- 5.3. Үнэт цаас гаргагч нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

## Зургаа. Хариуцлага

6.1. Хорооны Ажлын алба, хөрөнгийн биржийн холбогдох алба энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

----000----

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны Дуугаар сарын Дуугаар борийн 505дугаар тогтоолын хавсралт Чиэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тайлан гаргах загвар 5043239

#### Тайлангийн эхний хэсэг

Хаяг:			
Утас:			
Факс:			
Электрон хаяг:			

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

- 3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:
  - 4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Энэ хэсэгт үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээ, зах зээлийг тодорхойлж байр суурь эзлэх, зах зээлд бараа үйлчилгээгээ нийлүүлэх зэрэгт учирч буй болон тухайн бизнесийн салбарын өрсөлдөөний төлөв байдал томоохон өрсөлдөгчдийн тоо тэдгээрийн өрсөлдөх чадварын мэдээлэл болон тайлагнагч өөрийн өрсөлдөх чадварын талаар мэдээлэл тусгах.

- 5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:
  - 6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;

Хэрэв тайлагнагч нь компанийн нэгдэлд хамаарагддаг бол уг нэгдлийн талаарх товч мэдээлэл мөн тайлагнагчийн нэгдэл дэх үнэт цаас гаргагчийн байр суурийн талаар танилцуулна. Хэрэв тайлагнагч охин болон хараат компанитай бол түүний нэр, хууль ёсны хаяг, тэдгээр дэх эзэмшлийн хувь зэргийг тусгана.

Тайлагнагчийн толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл, үйл ажиллагааг хянадаг, шийдвэрт нөлөөлдөг эсвэл хянах, нөлөөлөх чадвар бүхий этгээдийн талаар, түүний эзэмшдэг саналын эрхтэй хувьцааны нийт хувьцаанд эзлэх хувь зэргийг тусгана.

7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

No	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1				
2				
3				

8. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь үнэт цаас гаргагчийн хувьцааг эзэмшиж байгаа бол/

No	Овог нэр	Иргэн бол эрхэлдэг ажил, Хуулийн этгээд бол байршил	Эзэмшиж буй хувьцааны хувь
1			
2			
3			

Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэлд ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, үнэт цаас гаргагчийн шийдвэрт чухал нөлөө үзүүлдэг этгээдтэй холбоотой дараах мэдээллийг тусгана:

- Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын болон ТУЗ-ийн гишүүдийн хоорондын гэр бүл, ураг төрлийн холбоотой байдлын талаар:
- Дээрх этгээдүүдийн сүүлийн 5 жилийн хугацаанд ажил эрхэлсэн байдал, ажиллаж байсан компанийн нэр, голлох бизнесийн үйл ажиллагааны талаар тайлагнагч байгууллагын толгой, охин эсвэл нэгдэлд хамаардаг компани болох эсэхээс үл хамааран мэдээлэх:
- Үнэт цаас гаргагчаас өөр газарт эрхэлж буй үйл ажиллагаа /ТУЗ, гүйцэтгэх удирдлагад ажилладаг зэрэг/:
- Үнэт цаас гаргагчийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь томоохон хувьцаа эзэмшигч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч этгээдээс байгаа эсэх талаарх мэдээлэл:
  - Дээрх этгээдүүд нь хоорондоо нэгдмэл сонирхолтой эсэх талаарх мэдээлэл.

### Тайлангийн хоёрдахь хэсэг

- 1. Үнэт цаас гаргагчйн аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд, түүний тайлбар тодруулга, аудитын байгууллагын дүгнэлт:
- 2. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар ийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан эсэх талаарх мэдээлэл:

3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас гаргагчийн хувьцааг эзэмшдэг эсэх талаарх мэдээлэл:

No	Овог нэр	Цалин урамшууллын хэмжээ	Хандив тусламжийн хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны хувь
1					
2.					
3					

Энэ хэсэгт тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, захиргааны, хяналтын болон менежментийн багийн гишүүдэд үнэт цаас гаргагч түүний толгой, хараат, охин компаниас олгосон нийт цалин хөлс, шагнал урамшууллын хэмжээ, бусад хэлбэрээр хүртсэн ашиг орлого зэрэг дараах мэдээллийг тусгана:

- Үндсэн цалин, шагнал урамшууллын дүн, гаргуулсан зардал бусад хандив тусламжийн мөнгөөр илэрхийлэгдэх дүн, урт хугацааны урамшуулал;
- Урамшууллыг аваагүй байгаа боловч олгохоор тооцсон бол энэ тухай мөн мэдээлнэ. Хэрэв урамшуулал, эсхүл ашиг хуваах хөтөлбөрийн дагуу хуваарилсан бол уг хөтөлбөр болон тухайн этгээд түүнд хэрхэн оролцсон;
- Үнэт цаас гаргагч түүний толгой, хараат, охин компаниас тэтгэвэр, түүнтэй ижил төстэй ирээдүйд үр ашиг хүртээх зорилгоор хадгалсан, хуримтлуулсан мөнгөн хөрөнгө;
- 4. Үнэт цаас гаргагчийн хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээлэл:

Энэ хэсэгт үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хувиарлах асуудлаар баримтлах бодлогыг тусгахын зэрэгцээ дараах мэдээллийг агуулна:

- Хэрэв өмнөх санхүүгийн жилд ногдол ашиг болон бусад санхүүгийн төлбөрүүд хийгдсэн бол тэдгээрийн мөнгөн дүн;
- Ногдол ашигт тавих хязгаарлалт, зарлах, олгох өдөр, тухайн оронд оршин суугч бус этгээд ногдол ашгаа хэрхэн хүртэх талаарх мэдээлэл;
  - ногдол ашиг хуваарилахгүй гэж шийвэрлэсэн бол түүний үндэслэл, тайлбар;
- 5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл.
  - 6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан.
  - 7. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан.
- 8. Монголын компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлсэн талаарх тайлан, хэрэв мөрдөөгүй бол түүний шалтгаан, тайлбар, хэзээ мөрдөж эхлэх хугацаа.

## Тайлангийн гуравдах хэсэг

- 1. Тайлант хугацаанд энэхүү журмын дагуу холбогдох заалтын дагуу тухай бүр нийтэд зарласан мэдээ мэдээллийн нэгтгэлийг энэ хэсэгт тусгана.
  - 2. Бусад холбогдох мэдээлэл.
  - 3. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээлэл.